

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2020 оны 04 дүгээр сарын 29

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2020 оны 04 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 5-р хуралдаан 4-р сарын 02-нд хуралдаж 10 асуудал хэлэлцэн 8 тогтоол батлан гаргаж, хуралдааны 3 тэмдэглэлээр үүрэг өгөв. Үүнд:

1. Монгол УИХ-ын болон аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулуудын хадгалах хугацаа дууссан саналын хуудсыг устгах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.

2. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 88,9 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэлээ.

3. Олон хүүхэд төрүүлж өсгөж “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах болзол хангасан аймгийн 27 сумын 423 эхийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

4. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд Батсүмбэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, тээврийн хэрэгслийг үнэ бууруулж худалдах жагсаалтыг батлан тогтоолын хэрэгжилтийг шуурхай хангаж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган Төрийн болон орон нутгийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэх арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

5. Хөгжлийн түүчээ Төв аймаг 2024” хөгжлийн хэтийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн цогцолбор төслүүдийн жагсаалтыг баталсан.

6. Баянцагаан, Өндөрширээт, Архуст сумдын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан тухай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга М.Отгонбат, “Эрхэт констракшин”, “Инженер геодези” ХХК-иудын мэдээллийг хэлэлцээд Мэргэжлийн зөвлөлийн болон Улсын экспертизийн дүгнэлтийн дагуу нягтлан үзээд өргөн мэдүүлэхийг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

7. Мал хаваржилт, төл хүлээн авалтын бэлтгэл ажлын явцын мэдээллийг хэлэлцэн аймаг, сумдын Засаг дарга нарт тэмдэглэлээр үүрэг чиглэл, зөвлөмж өглөө.

8. Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулахад сумдын сонгуулийн хороог мэргэжил арга зүйн удирдлагаар хангах аймгийн “Сонгуулийн хороо”-ны бүрэлдэхүүнийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах саналыг Сонгуулийн ерөнхий хороонд уламжлав.

9. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 15 дугаар хуралдааны “2020 оны төсөв батлах тухай” 02-р тогтоолын 4-р хавсралтад залруулга хийх тухай Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Ж.Даш-Яйчилын мэдээллийг хэлэлцээд Угтаалцайдам гэснийг Сүмбэр сум гэж залруулахаар шийдвэрлэсэн.

10. Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Төв аймгийн эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажиллаж, залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа 15 иргэний тодорхойлолтыг Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: “Гавъяат механикжуулагч цол”-оор 1, “Гавъяат багш цол”-оор 1, “Соёлын гавъяат зүтгэлтэн цол”-оор 1, “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 9, “Алтан гадас одон”-оор 36, “Цэргийн хүнэт медаль”-иар 2, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 15 байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 6-р хуралдаан 4-р сарын 23-ны өдөр хуралдаж хуралдаанаар нийт 5 асуудал хэлэлцэв.

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоо тогтоох, сонгуулийн тойрог байгуулах, тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, мандатын тоог тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоог 41-ээр тогтоож аймгийн Зуунмод, Батсүмбэр, Жаргалант, Заамар сумдын хүн амын тоо 5000-аас дээш тул тус бүр 2 тойрог болгож бусад сумдыг тус бүр 1, Зуунмод сумыг багийн тоогоор 6 тойрог болгож Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн нийт 35 тойрог байгуулав.

2. Аймгийн 2020 оны төсвийн 1-р улирлын гүйцэтгэл, аймгийн ИТХ-ын 2019 оны 15 дугаар хуралдааны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

3. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 6-р багийн нутаг дэвсгэрт байрлах 34 дүгээр байрны 6 айлын орон сууцыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталлаа.

4. Төрөөс малдчин талаар баримтлах бодлого, Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлж, мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

5. Хаврын тариалалтын бэлтгэл ажлын тухай мэдээллийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Аймгийн Засаг даргын зөвлөл 4 дүгээр сарын 20-ны өдөр хуралдаж 6 асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

“Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээ” 2020 оны урианы жилийн ажлын төлөвлөгөөний 1 дүгээр улирлын хэрэгжилтийг тооцон хорооны хурлаар хэлэлцүүлэхэд 43.33%-ийн гүйцэтгэлтэй байна. Хорооны хурлаар 6 ажил үйлчилгээг урианы жилийн ажлын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулахаар шийдвэрлэж аймгийн Засаг даргын 2020 оны А/244 дүгээр захирамжаар баталгаажуулсан. Мөн хорооны дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нар Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж буй банк, даатгалын байгууллага; худалдаа, нийтийн хоолны газар; авто тээвэр, такси үйлчилгээний хоршоо, мэдээллийн технологийн салбарын төлөөллүүдтэй уулзаж, хамтран ажиллаж санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан 15 хэлтэс, агентлагт 2020 оны урианы жилийн ажил, орон нутгийн бодлого, хүний нөөцийн хангалтын байдалд явцын хяналт-шинжилгээ хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

27 сумын 2020 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, урианы жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ хийж, сайжруулалт хийх арга зүйн зөвлөгөөг цахимаар өгсөн.

Аймгийн 2020 оны Нэгдсэн төлөвлөгөөний 6 бүлэг 214 арга хэмжээний 1-р улирлын хэрэгжилтийг тооцоход 89.8%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 47, хэрэгжих шатандаа 6, хэрэгжилт хангалтгүй 6, цаг үеийн байдлаас хойшилсон, хугацаа болоогүй 155 байна.

Аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэлийн баталсан удирдамжийн дагуу Зуунмод сумын 6 багт “Иргэдтэй хийх уулзалт”-ыг 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулав. Уулзалтын үеэр 63 иргэнээс 160 санал хүсэлт гаргасныг хүлээн авч шийдвэрлэлтийг тооцон хариу өглөө.

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн “Ажил сайжруулах төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу гадаад, дотоод хэрэглэгчдээс хэлтсийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөх санал асуулгыг цаасаар 108, ДУС-ээр 61, цахимаар 101 иргэн, хэрэглэгчээс авч дүн гарган нийтэд мэдээлсэн.

2020 оны 4 дүгээр сард МУЗГ-ын 11-11 төвөөс 4 өргөдөл ирснээс 2 өргөдлийг холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн, 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа хүлээгдэж байна.

Тайлант хугацаанд албан байгууллага, ААН-ийн дарга нарын нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх үүрэг чиглэлийг тэмдэглэлээр өгч хэрэгжилтийг тооцож байна.

Аймагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн мэдээллийг хэлтэс, агентлаг, сум бүрээр гаргуулан нэгтгэх ажил хийгдэж байна.

Төрийн албан хаагчдын Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдын бүртгэл мэдээллийг удирдлагын академид хүргүүлсэн.

2020 оны 04 дугаар сарын 29-ний байдлаар дээд шатны байгууллагаас ирүүлсэн 85 иргэний материалыг /Үүнээс ТАХ 21/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

Тайлант сард холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай 5 удаагийн цахим хурал хийсэн.

Төрийн үйлчилгээний ХУР систем нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг 20 суманд хүлээлгэн өгч, үйл ажиллагааг эхлүүлээ.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн хэмжээнд сул орон тооны захиалгыг шинэчлэн авч нийт 11 байгууллага, 27 сумын 45 төрлийн албан тушаалын 181 сул орон тооны судалгаа гарган хүргүүлж, 2020 оны 04 дүгээр сарын 17-ны цахим хуралд оролцов.

Төрийн албаны нөөцийн бүртгэл мэдээллийг 7 байгууллагын хүсэлтээр хүргүүлсэн.

Сургалтын мэдээлэл:

№	Сургалт зохион байгуулсан хугацаа	Сургалтад хамрагдсан	
		Байгууллага, албан тушаалтан	ТАХ-ийн тоо
1	2020.01.09	Сумдын ЕБС, Цэцэрлэгийн эрхлэгч нарын нэгдсэн сургалтанд Салбар зөвлөлөөс 2020 онд баритмлах чиглэл, хүний нөөцийн системийн бүртгэлийн тухай	54
2	2020.01.10	Сумдын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, МЭҮТ-ийн мэргэжилтэн нарт зориулсан сургалт	41
3	2020.01.13	Мэдээлэл харилцаа, холбооны газартай цахим систем аймгийн хэмжээнд нэвтрүүлэхтэй холбогдон	3

		ERP системийн таинлцуулга сургалтанд хамрагдав	
4	2020.01.22-23	Төрийн албаны Салбар зөвлөл, аймгийн ЗДТГ, МЕРИТ төсөлтэй хамтран “Багийн хамтын ажиллагаа хүчирхэг баг бүрдүүлэх нь” сэдэв сургалтыг сумын ЗДТГ-ын дарга, Бодлогын хэлтсийн болон зарим агентлагийн Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт зориулсан гэрчилгээ олгох сургалт	35
5	2019.01.29-30	Сумдын ИТХ. Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын нэгдсэн сургалт Төрийн албаны Салбар зөвлөлөөс 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, анхаарах асуудлын талаар нэгдсэн чиглэл өгч ажиллав.	79
6	2019.04.10	Сумдын ЗДТГ-ын дарга нарт Төрийн албаны Салбар зөвлөлөөс цаг үеийн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай чиглэл өгч ажиллав.	79
НИЙТ ДҮН		9 байгууллага, нэгж	239

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “**ТАЗСЗ**” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2020.04.28-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	17
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	4
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны ерөнхий шалгалтын зар	9
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	1
НИЙТ ДҮН		32

2020 оны 04 дүгээр сарын 29-ний байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	39	7	6	1	-
2	Өргөдөл, гомдол	5	4	3	1	-

Гадаад харилцаа: БНСУ-ын Кёнгү аймгийн Пёнтаек хотын захиргаатай хамтран ажиллах санамж бичгийн төслийн албан ёсны орчуулгыг хүргүүллээ. Тус хотын санхүүжилтээр хийгдэх аймгийн Нийтийн номын сангийн их засварын ажлын тендер зарлагдсан.

Япон улсын Тоттори мужид Хөдөө аж ахуйн дадлагажигч хүлээж авах тухай албан бичиг, удирдамжийн дагуу дадлагажигч сонгон шалгаруулах, холбогдох материалуудыг бүрдүүлэхээр бэлтгэл хангаж байна.

БНСУ-ын Коре их сургуулийн Анам эмнэлэгт аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүлээлгийн танхимд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг хүргүүлсэн.

Япон улсын Тоттори мужид аймгийн Нэгдсэн эмнэлгийн гемодиализын их эмч, техникч нарыг дадлагажуулахаар харилцан тохиролцоод байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2020 оны 4 дүгээр сард Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300-аад төрлийн үйлчилгээг **5763** иргэнд, өдөрт дунджаар 250-300 иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд

зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний мэдээллийг “Өлзий”, TBS, Төв, Live TV, Сүлд телевизүүд, аймгийн албан ёсны веб сайт, пейж хуудас, мэдээллийн болон урсдаг самбар зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд 4 дүгээр сард аймгийн веб сайтад 32, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 77 мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ.

Харин 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 4-н дугаарт 19 бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэн өгч, олон нийтэд хүргэсэн. Мөн бусад 7 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар 18 мэдээ мэдээлэл гарсан нь давтагдсан тоогоор 54 удаа цацагдсан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 12 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавихад 100%-тай байна. Хугацаа болоогүй 10 гомдол байна.

“Хөгжлийн түүчээ-Төв аймаг” 100 нүүртэй сэтгүүлийн эхийг бэлтгэн 2000 ширхэгийг хэвлүүлж, сум, байгууллагад тараалаа.

Сумдын ОНИМТАжилтнуудын сургалтыг 4 сарын 14-ний өдрөөс эхлэн явуулж эхлэсэн бөгөөд Өндөрширээт, Заамар, Зуунмод, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Сэргэлэн, Угтаалцайдам зэрэг 8 сумын ажилтнууд хамрагдсан.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын дарга, холбогдох хэлтсийн албан хаагчид Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Ковид-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл ахуй, халдвар хамгаалал, авто тээврийн хяналт, хүнсний чанар стандарт, мал эмнэлэг, эм био бэлдмэл, эмчилгээний чанар, боловсрол, соёл, ургамал хамгаалал, холбоо мэдээлэл, байгаль орчин, уул уурхайн хяналтын чиглэлүүдээр давхардсан тоогоор 62 төрлийн зөвлөмж, 81 төрлийн сэрэмжлүүлгийг 782 иргэн, аж ахуйн байгууллагуудад хүргүүлэн ажилласан. 651 иргэн, ААНБ буюу 83.2%-д хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж байна. Мөн байгууллага дээр болон Өндөр дов, 4 дүгээр зөрлөгийн постуудад 24 цагийн хариуцлагатай жижүүр ажиллаж, холбогдох мэдээ мэдээллийг удирдах албан тушаалтан болон МХЕГ-ын хариуцлагатай жижүүрт шуурхай мэдээлэн ажиллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар тэмдэглэлийн 2 дахь хэсэг, газрын даргын баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 19/04 тоот удирдамжийн дагуу Зуунмод сумын Ундром, Од, Номин супермаркет, Ар урт, Андууд хүнсний худалдааны газар, Алтан ураг, Самата зоогийн газруудад хяналт шалгалтыг хийв. Шалгалтаар хадгалалтын хугацаа дууссан, гарал үүсэл нь тодорхойгүй 18 нэр төрлийн 244 ширхэг, 154300 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг устгаж, хаяг шошгын зөрчилтэй 5 нэр төрлийн 63 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгэсэн.

Аймаг, орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдах, хувийн хэвшлийн байгууллагын хөрөнгөөр баригдах 8 байгууллагын үйлдвэрийн болон агуулахын, ажилчдын амралтын, орон сууцны, шатахуун түгээх станцын, спорт заалны, махын үйлдвэрийн өргөтгөлийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьчилсан хяналтыг хийж барилга байгууламжид эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж, 8 дүгнэлт гаргаснаас зөвшөөрсөн 2, татгалзсан 6 дүгнэлт байна.

Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц чанар, хадгалалтын нөхцлийг шалгасан. Хлорын шохой-1217 кг, Суперкил-105 кг, HiCOF- 77 кг, Халдвар хамгааллын хувцас -336 ширхэгийн нөөцтэй байна. Суперкилл халдваргүйтгэлийн бодисын хлорын идэвхийг тодорхойлох зорилгоор аймгийн Мал эмнэлгийн газарт хадгалагдаж буй “Суперкилл” халдаваргүйтгэлийн

бодисоос дээж авч итгэмжлэгдсэн лабораторит шинжүүлэхэд 32.7% идэвхит хлор агуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2020.03.19-ний өдрийн А/169 тоот захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 2015-2018 онд бэлтгэсэн өвс, тэжээлээс дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторит шинжлүүлэхэд 2020 оны 04 дүгээр сарын 07 өдрийн 20-764 тоот шинжилгээний дүнгээр өвсөнд аспергилиус, мукор, чийг 8,9%, хивгэнд мукор, сүрлэнд аспергилиус төрлийн мөөгөнцөр тус тус илэрсэн тул MNS 0592:2008, MNS 0961:2008 өвс, хивэгний стандартын шаардлага хангахгүй байна гэсэн улсын байцаагчийн 19-02-006-37 тоот дүгнэлт гаргасан.

Төлөвлөгөөт хяналт шалгалт: МХЕГ, ЭМДЕГ-ын хамтарсан 01/122 тоот удирдамжаар Эрүүл мэндийн даатгалын сан болон сангаас санхүүжиж буй аймгийн Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, Аксион мэдрэлийн хувийн эмнэлгийн үйл ажиллагаанд эмчилгээний чанар, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

Боловсрол, соёлын хяналтын чиглэлээр мэргэжлийн хяналтын байгууллагын төлөвлөгөөний дагуу Сэргэлэн суманд 19/40, 19/30 тоот удирдамжаар шалгалт, тандалт судалгаа хийж, 15 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг чиглэл өглөө. Мөн 01/120, 19/52 тоот удирдамжаар Аймгийн Музей, Нийтийн Номын сангуудад төлөвлөгөөт шалгалтыг хийлээ.

Мэргэжлийн хяналтын газрын 2020 оны 19/33 тоот удирдамжийн дагуу Зуунмод сумын Наран хүнсний цехийн үйл ажиллагаанд 1.7.1 кодтой гурилан бүтээгдэхний үйлдвэрлэлд хяналт шалгалт хийхэд 38 хувьтай буюу дунд эрсдэлтэй, 1.7.2 кодтой гурилан бүтээгдэхний үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл 41% үнэлэгдсэн. Улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагад 15 заалт оруулсан.

“НИК” ХХК-ийн Төв Зуунмод ШТС-1-д шалгалт хийж Газар эзэмших гэрээ байгуулаагүй зөрчлийг шалгалтын явцад арилгуулж, улсын байцаагчийн 2 заалт бүхий хугацаатай албан шаардлагыг хүргүүлж ажилласан.

Төлөвлөгөөт бус шалгалт: Төв аймгийн Сэргэлэн сумын өндөр довны постонд хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд Автотээврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд төлөвлөгөөт бус шалгалтыг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2020 оны 04 дугаар сарын 20 өдөр хүртэл хийж, зөрчил илэрсэн иргэн, аж ахуйн нэгжид анхааруулга сануулга, заавар зөвлөмж өгч, шаардлага биелүүлээгүй 3 жолоочид торгуулийн арга хэмжээ авсан.

Улсын онцгой комиссын 12 дугаар хурлаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ахуйн болон эмнэлгийн бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийлээ. Үүнд:

1. Цэвэрлэгээний түвшинг нэмэгдүүлэх, лагийн талбайг үнэргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, халдваргүйтгэл хийж байгаа бодисын тун, зарцуулалт, контактын хугацаа, үлдэгдэл хлор, хлор шингээлтэд хяналт тавьж ажиллах талаар Төв Чандмань ДЭХГ ХК-д 5 заалт бүхий хамтарсан албан шаардлага хүргүүлэв.

2. МХЕГ-аас ирүүлсэн ариутгах татуургын шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажиллах, талаар 10 заалттай зөвлөмжийг Төв Чандмань ХК-д хүргүүлсэн.

Төв Чандмань ДЭХГ ХК-ийн цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдэн гарч буй усанд хяналт шинжилгээ хийхэд 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 20-151 тоот шинжилгээний дүнгээр оролтын усанд гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нян илэрсэн, химийн шинжилгээгээр умбуур бодис, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр цэвэрлэх байгууламжаас гарч буй лагт хийсэн бичил амь судлалын шинжилгээний дүнгээр

лаганд клостридиун перфрингенсийн титр 0.1-ээс бага гэдэсний бүлгийн нян илэрсэн.

Цэцүүх трэйд ХХК-ийн химийн хортой бодисын сав баглаа боодлыг боловсруулах үйлдвэрт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр хийсэн. Шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр улсын байцаагчдийн хамтарсан албан шаардлага хүргүүлэхээр төлөвлөөд байна.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 04 дүгээр сард хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 114 сорьцыг шалгаж 393 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна. Үүнээс ундны ус болон үрийн төмсний 8 сорьц 11 үзүүлэлтээр химийн болон үрийн чанарын шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд: Дэлхий дахинд дэгдээд байгаа коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Аймаг орон нутгаас онцгой анхаарч ажиллаж байна. Улсын Онцгой комиссын 16, 17 дугаар хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэлийн дагуу Сумдад коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлж анхан шатандаа халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг авч ажиллах үүрэг чиглэл өгсөн.

“Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” ажлын хүрээнд Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг 45 байгууллага, 6 багт ариутгал халваргүйтгэл хийсэн.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 6.400.000 төгрөгийн үнэ бүхий гипохлорид кальци 1 тн ариутгал бодис худалдан авч Зуунмод сумын 2, 3, 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхийн нийт 1700 нүхэн жорлонд ариутгал хийсэн.

Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх зорилгоор Аймгийн Засаг даргын 2020 оны А/237 дугаар захирамжийн дагуу Зуунмод сумын “Өндөр дов”, “4-р зөрлөг” гэх газруудад Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрууд хамтран 2020.04.30-ны өдрийг дуустал 2 хяналтын цэг гарган ажилласан.

Аймгийн Шуурхай штаб 24 цаг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тухайн өдрийн илтгэх хуудас болон 27 сумын нөөцийн судалгааг өдөр бүр авч нэгтгэн УОК-ын цахим хаягаар хүргүүлж байна.

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу “Маск зүүцгээе” аяныг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж байна. Аяны хүрээнд ард иргэдэд чанга яригчаар “Маск зүүцгээе” санамжийг хүргүүлж, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, МХГ, сумдын ШШТабын ажлын хэсгүүд нийтийн эзэмшлийн гудамж, талбай худалдаа үйлчилгээний газраар хяналт шалгалт зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/225 дугаар захирамжаар Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, аймгийн хэмжээнд нийт нутгаар түймэр гарах эсдэл өндөртэй ойн сан бүхий 6 суманд 17 хяналтын цэг байгуулж Онцгой байдлын газрын алба хаагчид үүрэг гүйцэтгэж байна.

Төв аймгийн хэмжээнд 2020.04 сард объектын гал түймрийн дуудлага 6, зөрчлийн дуудлага 6, гамшиг ослийн дуудлага 1, ой хээрийн түймрийн дуудлага 4 ирж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаа.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн

цаг” зохиомжит нэвтрүүлгийн 04 сарын дугаарыг “Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хууль”-ийн сэдвээр бэлтгэн нийтэд хүргэлээ.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 49 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, 78 иргэн, байгууллагад зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа, эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 18 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангасан.

Аймгийн Захиргааны хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 4 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, 2 шүүх хуралдаанд оролцож ажиллалаа.

Аймгийн вэб сайтанд “Эрх зүйн сурталчилгаа” булан нээж, 6 хуулийн тайлбар, асуулт хариултын материалыг байршуулсан. Хууль эрх зүй хэсэгт www.e-khutuch.mn, www.legalinfo.mn сайтууд болон хэм хэмжээний акт, аймгийн шийдвэр гэсэн цэсүүдийг нэмж, баяжилт хийж эхэллээ.

Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зарласан “Байгалиа хамгаалъя” нэгдсэн аянд аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн ЗДТГ нэгдэж, сумдын салбар зөвлөлд тусгайлсан аяны төлөвлөгөө батлан хүргүүлж, видео шторик бэлтгэн олон нийтэд сурталчлан ажиллав. Аймгийн ГХУСАЗСЗ-өөс санаачлан орон нутгийн Төв телевизтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 1 жилийн хугацаанд хууль хяналтын байгууллагууд цувралаар оролцох “Түвшин-амгалан” нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэж байна.

Авлигатай тэмцэх газартай хамтран Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны талаар, сум хөгжүүлэх сангийн зээл олголт, зээлийн эргэн төлөлтөд анхаарах асуудлаар “Цахим хурал” хийсэн.

Хууль зүйн салбарын хүрээнд аймгийн төрийн 15 байгууллагад архив, албан хэрэг хөтлөлт, авлига, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

Үндэсний Аюулгүй Зөвлөлийн Ажлын албаны төлөөлөл аймгийн ИТХ, ЗДТГ, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудад 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд ажилласан. Энэ хүрээнд гадаад харилцаа, төрийн болон албаны нууц, шашны чиглэлээр хийсэн хяналт шалгалт, анхаарах асуудал, Ковид 19-тэй холбоотойгоор улс, аймгийн онцгой комиссын үүрэг чиглэлийн хэрэгжилтэд зөвлөн тусалж, үүрэг даалгавар өгсөн. “Нууц хамгаалах журам”-ыг боловсруулан Төв аймаг дахь Тагнуулын хэлтсээс санал авч, нэгтгэн сумдад төслийг хүргүүлээ.

Батсүмбэр сумаас шашны сүм хийд байгуулах хүсэлтээ ирүүлсэн 1 шашны байгууллагын материал, холбогдох бичиг баримтыг хянан үзээд хариуг хүргүүлсэн.

Архивын үйлчилгээ: Төрийн архивын эх баримтаас 259 иргэний хүсэлтээр 933 хуулбар хувь, 120 лавлагаа, 289 хөмрөгийн 933 хадгаламжийн нэгж ашиглан лавлагаа мэдээллээр үйлчилж, 2.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

4 хөмрөгийн 233 хадгаламжийн нэгжийн 7820 хуудас баримтын 50764 хүний нэр, 10561 заалтын тоо, тушаалын мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж, 4 хөмрөгийн 319 хадгаламжийн нэгжийн 10565 заалтын 12584 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 4 хөмрөгийн 1152 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн хэлтэс: Эд хөрөнгийн бүртгэл: Цахим санд нийт 55200 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 10022, Газар өмчлөх эрхийн 45178 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 18258.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 57.8 сая, үл

хөдлөх худалдан борлуулсны 47.1 сая, тэмдэгтийн хураамжаас 2.1 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 31 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 57 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Тэмдэгтийн хураамжийн орлого 1.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 241 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 хэргээр буюу 22.3 хувиар өсч, гэмт хэргийн илрүүлэлт 34.1 хувьтай байна.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-26, шүүхээр баривчлагдсан-66, албадан саатуулагдсан-18, ар гэрт нь хүлээлгэн өгсөн-8, нийт 118 иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Аймгийн онцгой комиссын шийдвэр, Засаг даргын А/249 дүгээр захирамжийн дагуу 10 сумын нутаг дэвсгэрийн хяналтын 21 цэгт цагдаагийн газрын 19, бусад байгууллагын 45 алба хаагч хяналт тавин ажиллалаа. Тайлант хугацаанд Шүүх хуралдаанд 1029 оролцогчтой эрүүгийн 122, иргэний 106, захиргааны 4, нийт 232 шүүх хуралдаанд журам сахиулж ажилласан. Шүүхийн байранд шүүгчийн туслах, нарийн бичиг, бусад ажилтантай уулзахаар ирсэн 1104 иргэний бичиг баримтыг шалгаж зохих журмын дагуу шалган нэвтрүүлж хяналт тавин ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 60 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 17 иргэнийг сум дундын шүүхээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4262 жолоочийг 140.0 сая төгрөгөөр торголоо.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Криминалистикийн шинжилгээ-55, Магадлан шинжилгээ-54, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-227, гарын мөрийн санг баяжуулсан-130, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 251 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
4-р сар	321	170	16	475	152	323	32.0%
	4335531.9	1050790.5	600644.5	4785677.9	609739.9	4175938.0	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Газар тариалангийн хүрээнд: Аймгийн хэмжээнд 95.4 мян.га-д үр тариа, 7.8 мян.га-д төмс, 1.6 мян.га-д хүнсний ногоо, 1.6 мян.га-д тэжээлийн таримал, нийтдээ 116.4 мянган га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн. Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангаж, аймгийн тарилалтын штабыг байгуулан, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэ оны хаврын тариалалтад 12.7 мян.тн буудайн үр шаардлагатайгаас нөөцөлсөн үр 6.4 мян.тн байна. Улаан буудайн үр 6.3 мян.тн, таримал тэжээлийн үр 1.7 мян.тн, нийт 8.0 мян.тн үр дутагдалтай байна. Дутагдалтай байгаа үрийг нийлүүлэх арга хэмжээ авч ХААДСантай 37 иргэн, аж ахуй нэгж 1670 тонн улаан буудай үр, 1 аж ахуй нэгжээс 250 тн тэжээлийн таримлын үр худалдан авах гэрээ байгуулж, “Жаргалант харвест” ХХК ОХУ-аас 150 тн улаан буудайн үр импортлох ажлуудыг зохион байгууллаа.

Тариалан бүхий 3 сумын 5500 га талбайд оготно устгал зохион байгуулж, тал хээрийн 2 сумын 40 га талбайд тэжээлийн олон наст царгас тариалахад дэмжлэг үзүүлсэн. 2020 онд хүнсний ногооны үйлдвэрлэл 1600 га-д тариалахад 19060 тн үр шаардагдах судалгаа гаргаж, ХШТФХ-ны салбар зөвлөл Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумдын тариалан эрхлэгчдээс 850 кг үрийг татан авч нийлүүлэв. Мөн НҮБ-ын ХХААБ-аас хэрэгжүүлж буй Монгол улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн (SECiM C2) хөрөнгө оруулалтаар Сүмбэр, Борнуур, Жаргалант, Эрдэнэ сумдын ногоочдын бүлгүүдэд 6.3 сая төгрөгийн чанар стандарт хангасан сортын үр, гарын авлага, автомакс дэмжлэг үзүүлсэн.

Мал аж ахуйн хүрээнд: Аймгийн хэмжээнд 12056 малчин өрхөд 4900.0 мянган толгой мал хаваржиж, үүнээс 2300.0 мянган толгой хээлтэгч мал төллөхөөс 922.0 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.7 хувьтай байна. Төл малын хорогдол нийт бойжсон төлийн 0.9 хувь буюу 12136 толгой, том малын зүй бусын хорогдол нийт малын 0.18 хувь буюу 8963 толгойг эзэлж байна.

Отор нүүдэл, бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй тэмцэх хэлэлцүүлгийг ХХААХҮЯамны Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газартай хамтран зохион байгуулахад Төв, Өвөрхангай, Дундговь аймгуудын ХХААГ-ын удирдлага, Эрдэнэсант, Баянхангай, Өндөрширээт, Дэлгэрхаан сумдын Засаг дарга нар оролцлоо.

Гадны аймаг, сумдын 652 өрхийн 593.0 мян.толгой мал оторлож, оторлосон малчдыг нүүлгэх ажлыг 04-р сарын 15-ны өдрөөс эхлүүлсэн боловч мал төллөж, хаврын хуурайшилтаас холын нүүдэл хийхгүй хүндрэл гарч байна.

Нийт нутгийн 80 орчим хувьд үлийн цагаан оготно тархан, бэлчээрийн талбайд нь үлийн цагаан оготны хэт олшрол болж, бэлчээрийн ургамлын 40-60 хувь нь хөнөөгдсөн. Бэлчээрийн хөнөөлт мэрэгчтэй тэмцэх ажлыг тал хээрийн 14 сумын 107.0 мянган га талбайд технологит хугацаанд эхлүүлэх, гүйцэтгэл 75.5%-тай буюу 80.8 мян/га талбайд устгал хийгдлээ.

2020 оны 04 дүгээр сарын байдлаар 2 багцад 17 инженерийн хийцтэй худаг шинээр гаргахаар "Буян ус"ХХК, "Виктор ус дриллинг" ХХК гэрээ байгуулан хайгуулын ажил хийгдэж байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд: “Төв аймгийн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт”-ийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт, хөгжлийн 16-н төсөл, Үйлдвэр технологийн паркийн танилцууллаа.

Аймгийн төвийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэн, Зуунмод мах боловсруулах үйлдвэрт 15.4 тонн хонины мах нөөцөлж, 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн борлуулж эхэллээ. Зуунмод сумын 6-н багийн хүнсний 7 дэлгүүрээр дамжуулан нөөцийн хонины ястай мах 6700 төгрөгөөр худалдаалж байгаа нь зах зээлийн үнээс 29.4 хувиар хямд байна.

Мал эмнэлгийн үйлчилгээ: “Биокомбинат” УТҮГ-тай вакцин нийлүүлэх гэрээ байгуулж, нийлүүлэлт 84.2%-тай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1803.6 мян толгой мал хамруулахаас вакцинжуулалт13.1%-тай байна.

Аймгийн хэмжээнд нийт 396.2 мян.м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт зохион байгууллаа.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр 5545 цахим гэрчилгээ олгож, 997 дуудлага хүлээн авч үйлчилгээ үзүүллээ. Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэгт 605 тээврийн хэрэгсэл, амьд мал 2620 толгой, мах, махан бүтээгдэхүүн-1242.083 тн, арьс шир-123393 ширхэг, ноос-24.6 мян.кг, ноолуур 170-тн, айраг-12.7 тн, дайвар бүтээгдэхүүн-22301 ш, 900 кг-цагаан идээнд хяналт хийж, Зөрчилтэй 8 тээврийн хэрэгсэл илрүүлэн холбогдох арга хэмжээ авсан.

Газрын харилцааны үйлчилгээ: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 53 дугаар тушаалаар Зуунмод сумын усны аж ахуйн баруун хэсгээр үерийн ус зайлуулах байгууламжийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, зураг төслийг “Гидро байгууламж” ХХК хийж гүйцэтгэлээ.

Зуунмод хотын цэвэр усан хангамжийн 2х2000м³ эзэлхүүнтэй усан сан, усан хангамжийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр “Өгөөмөр баян булаг” ХХК шалгарч 2398,9 сая төгрөгөөр гүйцэтгэж байна. Усан сангийн барилгын ажил суурь, хана, хучилт цутгалт хийгдэж, цэвэр усан хангамжийн шугам сүлжээ хийгдлээ.

Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөлд Зуунмод сумын 453 барилга байгууламжийн мэдээллийг бүрдүүлж, бүртгэн орууллаа.

Байгаль орчны чиглэлээр: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Зуунмод гол дагуу мод тарих, Эрдэнэ сумын ойн санд тархсан хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх, Зуунмод, Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл, Баянжаргалан суманд мод тарих ажлын даалгавар боловсруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулуулж байна.

Ковид-19 цар тахлын эрсдэлийг бууруулахад нийтийн эзэмшлийн талбай, орчны цэвэрлэгээг хийх, Зуунмод сумын гол дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажлыг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран зохион байгууллаа.

Баянцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй Э-Транс ХХК, Монголчехметалл ХХК, Минералплас ХХК-тай нөхөн сэргээлт хийх, 13 км хайрган хучилттай бүтээгдэхүүн тээвэрлэх зам барих гэрээ байгуулав.

Төв аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй газар эзэмших, нөхөн сэргээлт, ус ашиглах гэрээ байгуулах ажил 2020.03.30-04.03-ны өдрүүдэд зохион байгуулсан. Нөхөн сэргээлтийн гэрээг нэгтгэхэд 2020 онд шинээр 41.9 га газар хөндөгдөж, 171.25 га-д биологи, 197.57 га-д техник, 13.3 га-д дүйцүүлэн хамгаалах ажил хийгдэхээр байна. Ус ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлэх, урьд оны дутуу төлөлтийг барагдуулах ажлын хүрээнд 6 аж ахуйн нэгжээс 17.6 сая төгрөг төвлөрүүлсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, шалган туслах ажлыг 2020 оны 4 дүгээр сарын 13-17-ны хооронд Алтанбулаг, Баянцогт, Угтаалцайдам, Цээл, Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр сумдыг хамруулан зохион байгуулж, цаг үеийн асуудлаар үүрэг чиглэл өглөө. Тус хяналт шалгалтын хүрээнд Баянцогт суманд хууль бус гар аргаар ашигт малтмал олборлож байсан 5 иргэнийг саатуулан ухагдсан 8 нүхийг булуулж, сумын Байцаагчид багаж хэрэгслийг хүлгээн өгөв.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 103 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 82 төсөл, арга хэмжээнд тендер зарлаж хэрэгжүүлэхээс 4 дүгээр сарын гүйцэтгэлээр нийт 73

төсөл, арга хэмжээнд үнэлгээний хороог байгуулж, цахим тендер шалгаруулалтыг зохион байгуулснаар хэрэгжилт 89%-тай байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: Архуст, Алтанбулаг, Баян, Баяндэлгэр, Батсүмбэр, Мөнгөнморьт, Зуунмод, Сэргэлэн суманд худалдаа, үйлчилгээний 30 цэгт бүтээгдэхүүн үйлчилгээ, хэмжих хэрэгсэл, эзэлхүүн зарцуулалтын баталгаажуулалт хийлээ. Үүнд:

- Зуунмод, Баян сумын 22 худалдаа, үйлчилгээний цэгт тохирлын үнэлгээ хийж, 16 үйлчилгээ, 1 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.
- Баян, Сэргэлэн, Зуунмод сумын худалдаа үйлчилгээний 65 цэгийн 98 мөнгөн тооцооны массын хэмжих хэрэгсэлийг хянан баталгаажууллаа.
- Алтанбулаг, Баяндэлгэр, Зуунмод, Мөнгөнморьт, Эрдэнэ сумын Шатахуун түгээх станцын 41 хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажууллаа.
- УБЦТС ХХКомпани Зуунмод дах салбартай байгуулсан гэрээгээр 1 фазын 409 айл өрх, аж ахуй нэгжийн цахилгаан тоолуурт баталгаажуулалт хийлээ.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Эхийн алдар одонгоор шагнуулахаар санал ирүүлсэн 27 сумын 441 эхийн материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн 423 эхийн материалыг дэмжин Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүллээ.

Дэмжлэг үзүүлэх чиглэлээр 4 иргэнээс өргөдөл ирснийг хүлээн авч, 2 иргэнд 400.000 төгрөгийн дэмжлэг үзүүлж, 2 иргэнд хууль тогтоомжийн хүрээнд хариу өглөө.

Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Төв орон нутгийн хөтөлбөрөөс Аймгийн Засаг даргад хүсэлт ирүүлсний дагуу 04 дүгээр сарын 10-ны өдрийн Аймгийн Засаг даргын А\226 захирамжаар төр болон төрийн бус байгууллагын удирдлагуудыг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан “Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах төсөл”-ийн хүрээнд хамтран ажиллаж 6 сумын 261 зорилтот өрхийг сонгон 1 өрхөд 270.0 мян.төг, нийт 70.4 сая төгрөгийн тусламж үзүүлээд байна.

Мобиком Корпораци ХХК-тай хамтран элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл хангах зорилгоор 20 сумын 920 багш сурагчдад 11 сарын хугацаанд сар бүр 9GB дата эрхтэй дугаарыг үнэ төлбөргүй олгож, 726 сурагчийн шинэ дугаарт 500 нэгжээр эхний цэнэглэлтийг хийж, Цахим, Теле-Хичээл нөхөн үзэх боломжийг бүрдүүллээ.

Элсэлтийн ерөнхий шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд “Багшийн туслах 800” цахим боловсролын хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагаанд ашиглах, боломж бүрдүүлэх зорилгоор 20 сургуулийн 31 бүлэг болон аймгийн БСУГ-т “Багшийн туслах-800” аппликейшны 3 сарын эрх нээлгэн 1.728,000 төгрөгийн санхүүжилтийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас шийдвэрлэсэн.

2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр сумдын 12 жилийн сургалттай 20 сургуулийн захирал сургалтын менежер, 12 дугаар ангийн багш нартай цахим хурал хийлээ.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Коронавируст (Ковид 19) халдвар дэлхий даяар хурдацтайгаар тархан, Монгол улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож хөл хорио тогтоосонтой холбогдуулан телевизээр теле хичээлийг 2 дугаар сарын 3-ны өдрөөс 6-р сарын 1 хүртэл зохион байгуулж байна. ЭЕШ-д бэлтгэх чиглэлээр судлагдахуун бүрээр нийт 83 багш 96

теле хичээл зааж, Төв аймаг-ЭЕШ цахим хаяг болон БСУГ-ын вэбсайтад байршуулж аймгийн Төв ТВ-ээр олон нийтэд хүргээд байна.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын үндсэн чиг үүргийн жагсаалт, танилцуулга, санал боловсруулж БСШУС-ын яаманд хүргүүлэв.

Насан туршийн боловсролын үндэсний төвөөс тараагдсан 1-12 ангийн сурагчдын сурах бичгийг сумдад хүргүүлсэн.

Монгол туургатан театрын үйлчилгээ: 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Сарьсан багваахайн домог” хүүхдийн жүжгээр Live тоглолт зохион байгуулсан. Тус 6 дах удаагийн live тоглолтыг 4100 иргэд, хүүхэд багачууд үзсэн тандалттай байна.

Музейн үйлчилгээ: Төв аймгийн Эрдэнэ сумын Соёлын төвийн “Орон нутаг судлах танхим”-ын үзмэрийг дэглэж, ашиглалтад орууллаа. Эрдэнэ сумын нутаг дахь “Хаан жимс жуулчны бааз”-д байсан “Тарваган шийрийн гацаа буюу Зуунмодны тулалдаан болсон, хуучны ханз бичиг бүхий бичигтэй чулуун дурсгалыг Музейд хүлээн авч, үзүүлэгийн танхимд байрлуулаад байна. Түүх, археологи, угсаатны зүйн 100 ширхэг үзмэрийн зургийг сайжрууллаа.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: Номын сангийн үндсэн фондны төрөл анги болон үсэг дарааллын 19000 ширхэг номыг “Насанд хүрэгчдийн уншлагын танхим”, “Хүүхдийн уншлагын танхим”, “Гэрээр олгох уншлагын танхим”-д хуваарилан электрон каталогийн тулгалт хийсэн. “Дэлхийн номын өдөр”-ийг тохиолдуудан өөрийн сан хөмрөгт байгаа дэлхийн сонгодог зохиолуудын түүврээр “Дэлхийн шилдэг зохиолууд”, Олон улсын хүүхдийн номын өдөрт зориулж “Х. К. Андерсений үлгэрүүд” зэрэг сэдэвчилсэн номын үзэсгэлэнг үүдний танхимд нээлттэйгээр гаргаж, нийтийн номын сангийн Вэб сайт, Facebook page хуудсаар хүргэлээ.

Иргэдэд үйл ажиллагаагаа цахимаар хүргэх зорилгоор <http://library.to.gov.mn> хуудсыг ажиллуулж, 4-р сард 5 удаагийн мэдээ, 5 видео мэдээлэл оруулсан байна.

Хүүхэд эцэг эхийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, хүүхдийг бие даан хөгжүүлэх, гэрийн номын сантай болгох зорилгоор “Миний гэрийн номын сан” сэдэвт уралдааныг 03-р сарын 20-оос 04-р сарын 13-ны хооронд цахимаар зохион байгууллаа.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Аймгийн ЕБС-ийн сурагчдын дунд “Миний дуртай спорт” сэдэвт гар зургийн уралдаан, “Шатрын бодлого бодох”, Хөл бөмбөгийн “Хэн сайн жонглёрдох вэ” тэмцээн, Гар дээр суниалтын тэмцээн, Таеквондогийн дасгалыг хэн сайн хийх вэ, шагайн харваа, бага, дунд, ахлах ангийн сурагчдын гэртээ хийх гимнастикийн дасгалын цахим уралдаануудыг зарлаж, 220 гаруй сурагчид оролцож 81 хүүхэд, 3 сургууль, 3 биеийн тамирын багш шалгаран алт, мөнгө, хүрэл медалиар шагнагдлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Залуучууд хөгжлийн төвөөс эх хэлээрээ кирилл үсгээр зөв бичиж, хэл соёлоо эрхэмлэн дээдлэхийг олон нийтэд уриалах зорилгоор 2020 оны 04 дүгээр сарын 07-ноос 05 дугаар сарын 07-ны өдрүүдэд “Эх хэлний дархлаа” цахим аяныг зохион байгуулж байна. Тус контентуудад давхардсан тоогоор 1219 иргэн хандсан байна.

2020 оны 03 дугаар сарын 06-аас 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд “Хамтдаа хөгжье” цахим аяныг зохион байгуулахад 18 сумын 99 хүүхэд оролцсноос Заамар сумын Шижир алт цэцэрлэг, Баянцогт сумын 11б анги “Шилдэг анги”-ар тус тус шалгарлаа.

“ХАБЭА”-н сарын аяны хүрээнд “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-аар 12 цуврал зурагт хуудас бэлтгэн байгууллагын фэйсбүүк хаягаар олон нийтэд хүргэж, 265 хандалттай сурталчлав.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх арга зүй” цахим сургалтад хүүхэд хамгааллын бүлгийн 4 гишүүн, байгууллагын 4 албан хаагч хамрагдлаа.

Монгол Улсын залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, хүүхэд залуучуудыг тасралтгүй хөгжих боломжоор хангах зорилгоор гитарын цахим хичээлийн 2 дугаар, Photoshop-ийн цахим хичээлийн 3 дугаарыг цахим орчинд /facebook, youtube, M+plus/ байршууллаа. Давхардсан тоогоор 2082 хандалт авсан.

Ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх зорилгоор “Архины тухай мэргэд” цуврал постерийг бэлтгэн түгээхэд 10395 хандалт авсан байна.

Гал түймрийн улмаас гэр оронгүй болсон Мөнгөнморьт сумын иргэн Ч-ын 4 хүүхдэд 753.000 төгрөгийн үнэ бүхий хувцас, сурагчийн дүрэмт хувцасны тусламж дэмжлэг, Баянцагаан сумын иргэн С-ын хүү А-т 208.100 төгрөгийн амин дэм, нэмэлт хоол хүнсний тусламж үзүүлээ.

Хүүхэд хамгааллын түргэвчилсэн үнэлгээг 9 сумын 137 өрхөд хийж программд шивсэн. ХНХ-ын сайдын 2020 оны “Хүүхэд хамгаалагч туршилтын төслийг хэрэгжүүлэх тухай” А/55 дугаар тушаалын хүрээнд аймагт 2 хүүхэд хамгаалагч ажиллаж байна.

Зөвлөгөө өгөх төвөөр гэр бүлийн хүчирхийлэлийн чиглэлээр 3, хүүхдийн эрхийн зөрчлийн чиглэлээр 3, нийт 6 хүн үйлчлүүлээ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2020 оны 4-р сарын байдлаар 1820 иргэнд 1317.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1149 иргэнд 401.5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 918 иргэнд 221.2 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 501 ахмад настанд 78.2 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 5151 ахмад настанд 417.9 сая төгрөгийн насны хишиг, 237 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 34.9 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 4130 иргэнд 213.8 сая төгрөг, жирэмсэн 831 эхэд 100.7 сая төгрөгийн тэтгэмж, алдар цолтой 59 ахмад настанд 38.0 сая төгрөг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4511 эхэд 872.4 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 284 эх /эцэг/-т 117.0 сая төгрөг, 2 ихэр хүүхэд төрүүлсэн 6 эхэд 12.0 сая төгрөг, алдарт эхийн 1,2-р одонтой 8381 эхэд 941.2 сая төгрөгийг тус тус олгосон.

ӨМНСанд бүртгэлтэй 18508 өрхийн 32662 хүүхэд сар бүр хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээнд хамрагдаж 5225.9 сая төгрөгийг олгосон байна. Шинэ төрсөн 188 хүүхдийн мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн. 1204 өрхийн 3308 том хүн, 3454 хүүхэд сард 80560.0 мянган төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэв.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 52 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 4 ажил олгогч байгууллага, иргэн, 20 сул чөлөөтэй ажлын байр, 16-н ажилд зуучлагдсан иргэн, 299 шинэ ажлын байрыг мэдээллийн санд оруулсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаагүй төлбөрт “Уулс Заамар” ХХК-аас 15821.2 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт давхардсан тоогоор 240 иргэнээс 115095.7 мянган төгрөг төвлөрүүлээд байна. 2014-2017 онд хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 40 иргэний 36510,0 мянган төгрөгөөс 18 иргэний 10834.0 мянган төгрөг төлүүлсэн.

Дэлхийн банкны санхүүжилтээр ХААН банкаар дамжуулан олгогдох “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд 5 иргэнд 46.0 сая төгрөгийг олгож, 10 шинэ ажлын байр бий болсныг мэдээллийн санд бүртгэсэн.

ХЭДСангаас ажил олгогчийг дэмжих урамшуулалд 4040.0 мянган төгрөг, түрээсийн хөнгөлөлтөд 1388.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний зардалд 2888.0 мянган төгрөг, нийт 8316.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурал 2 удаа хуралдаж, нийт 180 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 27 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 148 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 4 иргэн цуцалж, 1 иргэн буцаасан байна.

2020 оны 1-р улирлын байдлаар Дотоодын хяналт шалгалтаар 20 ажил олгогчтой холбоотой 5.6 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.7 сая төгрөг буюу 83% зөрчлийг барагдуулсан.

Аймгийн хэмжээнд 14341 тэтгэвэр авагчдад 5.4 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгож, 449 архивын лавлагаа, 302 тодорхойлолт гарган иргэд, даатгуулагчдад үйлчиллээ.

Аймгийн хэмжээнд 101 хөдөлмөрийн чадвараа түр алдсан иргэдийн тэтгэмжид 19.7 сая, жирэмсэн амаржсаны тэтгэмж 115 даатгуулагчид 177.6 сая, ажилгүйдлийн тэтгэмж 48 даатгуулагчид 45.2 сая төгрөг, ҮОМШӨ-хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 1 даатгуулагчийн 200,8 мян.төг, нийт 242.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор баталсан “Зарим иргэний тэтгэврийн нэмэгдүүлэхэд баримтлах журам”-ын дагуу нийт 1534 тэтгэвэр авагчдад 76.7 сая төгрөгийн нэмэгдэл олгоод байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Аймгийн хэмжээнд 2020 оны 03 сарын байдлаар 268 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 16 тохиолдлоор өссөн ба 267 нярай бүртгэгдсэн байна. Нийт 72880 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 22478, амбулаторийн үзлэг 35678, идэвхтэй хяналтын 6746 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 5347 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 1389 буюу 25.9%, осол гэмтлийн дуудлага 122 буюу 2.28%-ийг эзэлж байна. Стационарт 3805 хүн эмчлэгдэн нийт 27705 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 7,3 байна.

Магадлан итгэмжлэлд АНЭ, Баян, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Баянцогт сумын Эрүүл мэндийн төвүүд, Арга билэг сувилал, Аксион эмнэлгүүдийг хамруулсан.

Халдварт өвчний нийт сэжигтэй 12 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс хачигт халдвар 3, гахайн хавдар 1, салхин цэцэг 1, Гэдэсний халдвар 3, хоолны хордлого 4 тус бүр бүртгэгдсэн байна. Хавьтлын судалгааг хийж, голомтын ариутгал халдваргүйтгэл хийсэн. Томуу, томуу төст өвчин өмнөх оны мөн үеэс 4.3%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Зуунмод сумын 6 багийн гэр хорооллын айлуудын 2989 нүхэн жорлонд, 8 аж ахуй нэгжийн 4650 мкв талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийж, тусгаарлан ажиглах 3 байранд /Ахмадын сувилал, Баянбайгаль, Баянхангай амралтын газар/ эцсийн халдваргүйжүүлэлтийг 5780 мкв талбайд хийж гүйцэтгэв.

Аймгийн харьяат тусгаарлан ажиглах байрнаас гарч гэрийн тусгаарлалтад шилжсэн 19 иргэнд харьяа Эрүүл мэндийн төвүүд өдөр тутам хяналт тавьж байна.

Дэлхийн зөн ОУ-ын 8.9 сая төгрөгийн санхүүжилтээр “Аюулгүй ус” төсөл хэрэгжүүлж, Зуунмод сумын 4-р багийн зорилтот 50 өрх, 130 хүүхдэд усны зориулалтын сав, гарын алчуур тараан “Хуванцар савны хэрэглээ”, “Усны аюулгүй байдал эрүүл ахуй” сэдвээр сургалт зохион байгуулан, зөвлөмж өгч ажиллалаа. Тус байгууллаас 6.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэглэл хүлээн авч 8 сумын Эрүүл мэндийн төвд хуваарилан өгсөн.

Солонгосын сайн дурын байгууллага 10000 ширхэг нэг удаагийн маск, иргэн 24 ширхэг халуун хэмжигч аппарат хандивласан. Эрүүл мэндийн байгууллагуудын хувийн хамгаалах хэрэгслийн бэлэн байдал 60.0-90.0% болж нэмэгдсэн байна.

ЭМЯ-ны 108.0 сая төгрөгийн санхүүжилтээр Бүрэн сумын Эрүүл мэндийн төвд рентген аппарат нийлүүлэгдсэн.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлого: Орлогын төлөвлөгөө 3 дугаар сарын байдлаар орон нутаг 1030,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 972,6 сая төгрөг төвлөрүүлж 94,3 хувьтай, 5,7 хувиар орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 3465,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 4313,8 сая төгрөг төвлөрүүлж 124,5 хувьтай, 24,5 хувиар давуулан биелүүлсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлтийг 1290,1 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 124,7%-тай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баяхангай, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Дэлгэрхаан, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Зуунмод зэрэг 14 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Батсүмбэр, Баянчандмань, Бүрэн, Жаргалант, Заамар, Сэргэлэн, Угтаал, Цээл, Эрдэнэсант, зэрэг 10 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян, Баянжаргалан, Эрдэнэ нийт 3 сум байна.

Төсвийн зарлага санхүүжилт: Сумдад эхний 02 сарын байдлаар нийт 13535.8 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Сумдад эхний 03 сарын байдлаар нийт 17830,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 6679,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 4493,9 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 2185,1 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 2270,0 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 2154,5 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 115,5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 197,3 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 187,7 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 8496,7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 5492,4 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 3004,3 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлага: 2020 оны 3-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 159143,5 мянган төгрөгийн авлага, 199909.8 мянган төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 51051,2 мянган төгрөг буюу 25.5 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 12693,7 мянган төгрөг буюу 6.4 хувь нь цалингийн өглөг, 5269.1

мянган төгрөг буюу 2.6 хувь нь НДШимтгэлийн өр, 13014.2 мянган төгрөг буюу 6.5 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 38708.0 мянган төгрөг буюу 19.4 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 79173,6 мянган төгрөг буюу 39,6 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймаг, сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, сум, байгууллагад “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх бэлтгэл ажил болон цаг үеийн ажлын явцыг эрчимжүүлэх зорилгоор 15 хэлтэс, агентлаг, харьяа байгууллагад зөвлөн туслах чиглэлээр ажиллаж, аймгийн Засаг даргын 03 тоот албан даалгавар гарган хэрэгжилтийг улирал бүр тооцохоор шийдвэрлэсэн.

Аймгийн ЗДТГ-ын ISO 9001:2015 стандартад хийсэн дотоод аудитын дүгнэлтэд үндэслэн удирдлагын дүн шинжилгээний хурал хийж, 10 асуудлыг шийдвэрлэв. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, 5S зарчим сэдвээр 27 сумын 130 албан хаагчид цахим сургалт зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимжуулах ажлын хүрээнд “Ухаалаг засаглал” ТББ-тай хамтран www.plan.igovernment.mn цахим хуудсанд аймгийн ЗДТГ-ын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг оруулах бэлтгэл хангаж байна.

Санхүүгийн хяналтын чиглэлээр: 2020 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад сумдын Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сан, Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 он, Баянчандмань сумын политехникийн коллеж, Эрдэнэ сумын МСҮТ, Зуунмод сумын МСҮТ, Сүмбэр, Жаргалант сумын төсөвт байгууллагууд, аймгийн Музей, БСУГ, Монгол туургатан театр, ХХААЖДҮГ, Баянжаргалан сум, Баяндэлгэр, Баян, Сэргэлэн сумын төсөвт байгууллагууд, аймгийн Мал эмнэлгийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нийт 229924.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 66051.9 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 163872.1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага тогтоов. Улсын байцаагчийн актаас 3083.1 мянган төгрөгийг барагдуулсан байна. Өмнөх оны актын үлдэгдэл 109224.0 мянган төгрөгөөс 14142.9 мянган төгрөг төлөгдөж 95.1 мянган төгрөгийн акт барагдаагүй байна.

Найм. Цэргийн штабын хүрээнд:

МУЗГ-ын 2019 оны мн/250, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын н/65 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/232 захирамжаар 2020 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг 4 дүгээр сарын 21-30-ны өдрүүдэд 13 суманд зохион явууллаа. Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллахдаа нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, нэг дор 5-аас дээш цэрэг татагдагч иргэнийг цуглуулахгүй, халууныг үзэн, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, амны хаалт зүүлгэн үзлэгийг явууллаа.

Засгийн газрын 2020 оны 93 дугаар тогтоолын дагуу Цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаах 13 сумын 50 гаруй иргэнтэй гэрээ байгуулав.